



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ.
САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ
/Газрын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 28

Дугаар 35-00/08

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн шалгалт хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, шалгалтын үндэслэл:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5⁴ дугаар зүйлийн 5^{4.1} дэх хэсгийг үндэслэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17, 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/253 дугаартай "Монгол улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах" ажлын хэсэг байгуулах тухай тушаалаар 21 аймгийн 330 сумын 2003-2023 онуудад эрх бүхий этгээдийн шийдвэрээр газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмжийг хүргүүлсэн.

Энэхүү хяналт шалгалтын хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан норм, норматив, дүрэм, журам, стандартад үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний саналыг тодорхойлж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхэд гүйцэтгэлийн хяналт шалгалтын зорилго оршино.

1535080018

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, объектын нэр:

2.1. 21 аймгийн 330 сумын 2003-2023 онуудад эрх бүхий этгээдийн шийдвэрээр газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд хүргүүлсэн улсын байцаагчийн албан шаардлага болон ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийн биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийнэ.

2.2. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймаг, сумдын Засаг дарга, газрын даамлууд хамрагдана.

2.3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй олгосон газруудын зөрчлийг хууль тогтоомжийн хүрээнд арилгуулсан эсэх.

2.4. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгоогүй газруудыг хууль тогтоомжийн хүрээнд зөрчил арилгах арга хэмжээг зохион байгуулсан эсэх.

2.5. Гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлсэн зөрчлийг арилгуулсан эсэх.

2.6. Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбарыг үнэн зөв бүртгэгдсэн эсэх, нэгж талбарыг нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан эсэх.

2.7. Нэгж талбарын цахим болон цаасан хувийн хэргийн хавсралт баримт, материалыг үнэн зөв бүрдүүлэн системд оруулсан эсэх.

2.8. Хяналтын тайлан, үр дүнг үндэслэн авах арга хэмжээний санал боловсруулах.

Гурав. Шалгалтын төрөл:

Гүйцэтгэлийн хяналт шалгалт.

Дөрөв. Шалгалтын арга:

4.1. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон эрх зүйн бусад баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2. Улсын (ахлах) байцаагч нь баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичгүүдийг гаргуулж авах, тулгаж үзэх, хувилж авах, хяналт шалгалтын явцад болон илэрсэн зөрчил, дутагдлыг баримтжуулан фото зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг аргуудаар хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалт хийх бүрэлдэхүүн:

5.1. Орон нутагт хяналт шалгалтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчид;

5.3. Шаардлагатай тохиолдолд аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох мэргэжилтэн нарыг татан оролцуулан хамтран хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

Шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах:

7.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчид гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын дүн, танилцуулгыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын нийтлэг журам”-ын 25 дахь хэсэгт заасны дагуу нэгтгэж тайланг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2026 оны 10 дугаар сарын 01-ний дотор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн улсын ахлах байцаагч Г.Энхжин (enkhjin.g@gazar.gov.mn)-ийн цахим хаягаар хавсралт хүснэгтийн дагуу гаргаж ирүүлэх. (Хавсралт 1, 2)

7.2. Гүйцэтгэлийн хяналт шалгалтын нэгдсэн дүнг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох газар хүргүүлж ажиллана.

